СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** СЭА-2022/130-НА-СТА-ТШЗ


Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум

2022 он

ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК

Утас: 99102291 Цахим хаяг: Nitsbalance@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1. Аудитын санал дүгнэлт ........................................................ **Error! Bookmark not defined.**

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................................ 2

3. Аудитын тайлан ........................................................ 12

3.1 Ерөнхий зүйл ........................................................ 12

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........................................................ 12

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........................................................ 13

3.4 Материаллаг байдал ........................................................ 14

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........................................................ 14

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........................................................ 14

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........................................................ 16

3.8 Аудитын гол асуудал ........................................................ 16

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........................................................ 16

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........................................................ 16

3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал ........................................................ 17

4. Аудитын илрүүлэлт ........................................................ 17

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........................................................ 18

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| АОУС | Аудитын олон улсын стандарт |

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/130-НА-СТА-ТШЗ

танай ______________-ны № ______________-т

МАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 4 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.НАРАНГЭРЭЛ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.



018020230

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **31,390,679.32** | **42,089,961.82** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **0.00** | **0.00** |
| **32** | **БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | **0.00** | **0.00** |
| **33** | **АВЛАГА** | **0.00** | **0.00** |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **0.00** | **0.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **31,390,679.32** | **42,089,961.82** |
| **35100** | **Түүхий эд материал** | **738,158.00** | **861,717.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 690,878.00 | 758,067.00 |
| 35130 | Эм боох материал | 47,280.00 | 103,650.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **30,652,521.32** | **41,228,244.82** |
| 35420 | Аж ахуйн материал | 1,202,390.00 | 8,062,033.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 469,850.00 | 92,810.00 |
| 35460 | Хүнсний материал | 383,026.00 | 571,507.90 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 28,597,255.32 | 32,501,893.92 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,200,946,845.60** | **4,116,746,091.64** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **4,200,946,845.60** | **4,116,746,091.64** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **4,188,677,512.24** | **4,104,912,758.24** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 4,212,100,000.00 | 4,212,100,000.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -228,155,416.32 | -298,357,082.88 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 123,401,772.91 | 146,122,572.91 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -59,394,671.55 | -82,093,178.15 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 159,631,885.81 | 160,839,108.87 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -29,397,217.04 | -43,790,420.90 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 6,997,000.00 | 7,997,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -1,399,400.04 | -2,798,800.08 |
| 39217 | Ном | 4,893,558.47 | 4,893,558.47 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **12,269,333.36** | **11,833,333.40** |
| 39301 | Программ хангамж | 2,180,000.00 | 2,180,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -910,666.64 | -1,346,666.60 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 11,000,000.00 | 11,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **4,232,337,524.92** | **4,158,836,053.46** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **0.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **0.00** |
| **42200** | **Урт хугацаат зээл** | **0.00** | **0.00** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **4,232,337,524.92** | **4,158,836,053.46** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **4,232,337,524.92** | **4,158,836,053.46** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 11,000,000.00 | 11,000,000.00 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **4,221,337,524.92** | **4,147,836,053.46** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 4,293,764,082.15 | 4,240,384,468.82 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -72,426,557.23 | -92,548,415.36 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **4,232,337,524.92** | **4,158,836,053.46** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,499,517,318.88** | **1,429,609,775.37** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **34,708,679.88** | **18,540,907.66** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **34,708,679.88** | **18,540,907.66** |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 21,225,202.00 | 3,833,023.06 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 13,483,477.88 | 14,707,884.60 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,464,808,639.00** | **1,411,068,867.71** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,307,607,700.00** | **1,201,799,300.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,307,607,700.00 | 1,201,799,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **70,000.00** | **21,913,917.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 21,753,917.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 70,000.00 | 160,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **157,130,939.00** | **187,355,650.71** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 157,130,939.00 | 187,355,650.71 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,566,446,654.20** | **1,520,197,644.73** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,566,446,654.20** | **1,520,197,644.73** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,366,441,325.23** | **1,477,519,989.32** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **933,324,637.03** | **964,800,464.59** |
| 210101 | Үндсэн цалин | 655,694,767.46 | 620,853,185.48 |
| 210102 | Нэмэгдэл | 202,766,346.67 | 276,114,925.58 |
| 210104 | Урамшуулал | 74,863,522.90 | 67,832,353.53 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **124,702,118.00** | **129,210,607.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 89,120,677.00 | 90,059,507.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,329,656.00 | 9,787,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,463,725.00 | 7,830,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,865,931.00 | 1,957,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,922,129.00 | 19,575,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **156,462,239.00** | **186,910,050.71** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,930,970.00 | 9,025,488.00 |
| 210302 | Түлш, халаалт | 138,569,180.00 | 166,763,295.71 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,962,089.00 | 11,121,267.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **9,166,436.20** | **11,701,200.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,081,230.00 | 1,495,620.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 731,430.00 | 800,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 925,200.00 | 1,722,040.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,714,509.20 | 830,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,274,967.00 | 1,038,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,439,100.00 | 8,498,464.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **22,715,272.00** | **26,670,200.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 341,620.00 | 1,265,300.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,927,402.00 | 18,553,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10,446,250.00 | 6,851,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **8,189,900.00** | **30,277,900.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 635,000.00 | 18,100,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,554,900.00 | 12,177,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **464,400.00** | **506,500.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 464,400.00 | 506,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,273,440.00** | **13,566,090.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,279,500.00 | 12,414,090.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 | 1,152,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 273,940.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **109,142,883.00** | **113,876,977.02** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,396,607.68 | 0.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,245,560.00 | 4,748,200.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 91,500,715.32 | 109,128,777.02 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **200,005,328.97** | **42,677,655.41** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **30,085,405.00** | **33,911,300.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 29,085,405.00 | 33,211,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 700,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **169,919,923.97** | **8,766,355.41** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 169,919,923.97 | 8,766,355.41 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **(66,929,335.32)** | **(90,587,869.36)** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **5,497,221.91** | 1,960,546.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 5,497,221.91 | 1,960,546.00 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **(72,426,557.23)** | **(92,548,415.36)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| 1 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **11,000,000.00** | **4,293,764,082.15** | **4,304,764,082.15** |
| 2 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **11,000,000.00** | **4,293,764,082.15** | **4,304,764,082.15** |
| 3 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | (72,426,557.23) | (72,426,557.23) |
| 4 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **11,000,000.00** | **4,221,337,524.92** | **4,232,337,524.92** |
| 5 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **11,000,000.00** | **4,221,337,524.92** | **4,232,337,524.92** |
| 6 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 19,046,943.90 | 19,046,943.90 |
| 7 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **11,000,000.00** | **4,240,384,468.82** | **4,251,384,468.82** |
| 8 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | (92,548,415.36) | (92,548,415.36) |
| **9** | **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **11,000,000.00** | **4,147,836,053.46** | **4,158,836,053.46** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,469,790,939.00** | **1,411,068,867.71** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,469,790,939.00** | **1,411,068,867.71** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,307,607,700.00** | **1,201,799,300.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,307,607,700.00 | 1,201,799,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **5,052,300.00** | **21,913,917.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 21,753,917.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 5,052,300.00 | 160,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **157,130,939.00** | **187,355,650.71** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 157,130,939.00 | 187,355,650.71 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,459,171,939.00** | **1,389,973,867.71** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,459,171,939.00** | **1,389,973,867.71** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,258,928,422.03** | **1,347,296,212.30** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **933,324,637.03** | **964,800,464.59** |
| 210101 | Үндсэн цалин | 655,694,767.46 | 620,853,185.48 |
| 210102 | Нэмэгдэл | 202,766,346.67 | 276,114,925.58 |
| 210104 | Урамшуулал | 74,863,522.90 | 67,832,353.53 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **124,702,118.00** | **129,210,607.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 89,120,677.00 | 90,059,507.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,329,656.00 | 9,787,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,463,725.00 | 7,830,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,865,931.00 | 1,957,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,922,129.00 | 19,575,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **156,462,239.00** | **186,910,050.71** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,930,970.00 | 9,025,488.00 |
| 210302 | Түлш, халаалт | 138,569,180.00 | 166,763,295.71 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,962,089.00 | 11,121,267.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **7,770,100.00** | **11,701,200.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 757,100.00 | 1,495,620.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 800,000.00 | 800,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 645,200.00 | 1,722,040.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 622,200.00 | 830,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,697,700.00 | 1,038,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,247,900.00 | 5,814,840.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **22,238,578.00** | **26,670,200.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 388,900.00 | 1,265,300.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,212,378.00 | 18,553,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10,637,300.00 | 6,851,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,766,700.00** | **12,177,900.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 739,100.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,027,600.00 | 12,177,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **464,400.00** | **506,500.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 464,400.00 | 506,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,470,450.00** | **10,571,090.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,750,450.00 | 9,419,090.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 | 1,152,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **7,729,200.00** | **4,748,200.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,200,000.00 | 0.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,529,200.00 | 4,748,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **200,243,516.97** | **42,677,655.41** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **30,124,393.00** | **33,911,300.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 29,124,393.00 | 33,211,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 700,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **199,200.00** | **0.00** |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 199,200.00 | 0.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **169,919,923.97** | **8,766,355.41** |

| | | | |
|---|---|---|---|
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 169,919,923.97 | 8,766,355.41 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **10,619,000.00** | **21,095,000.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **10,619,000.00** | **21,095,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **10,619,000.00** | **21,095,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **10,619,000.00** | **21,095,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 10,619,000.00 | 21,095,000.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(10,619,000.00)** | **(21,095,000.00)** |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | **0.00** | **0.00** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **0.00** | **0.00** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| 100 | Тохируулгын орлого, зарлагын зөрүү | 0.00 | 0.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,392,498,500.00** | **1,387,064,693.30** | **5,433,806.70** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,392,498,500.00** | **1,387,064,693.30** | **5,433,806.70** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,358,587,200.00** | **1,332,233,135.89** | **5,433,806.70** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **963,778,600.00** | **959,598,085.18** | **4,180,514.82** |
| 210101 | Үндсэн цалин | 630,908,400.00 | 615,650,806.07 | 15,257,593.93 |
| 210102 | Нэмэгдэл | 275,829,700.00 | 276,114,925.58 | -285,225.58 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 0.00 | 0.00 |
| 210104 | Урамшуулал | 57,040,500.00 | 67,832,353.53 | -10,791,853.53 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **128,724,900.00** | **128,724,900.00** | **0.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 89,573,800.00 | 89,573,800.00 | 0.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,787,800.00 | 9,787,800.00 | 0.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,830,200.00 | 7,830,200.00 | 0.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,957,500.00 | 1,957,500.00 | 0.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,575,600.00 | 19,575,600.00 | 0.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **190,253,600.00** | **186,910,050.71** | **3,343,549.29** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,198,800.00 | 9,025,488.00 | 2,173,312.00 |
| 210302 | Түлш, халаалт | 161,889,500.00 | 166,763,295.71 | -4,873,795.71 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 17,165,300.00 | 11,121,267.00 | 6,044,033.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **10,723,200.00** | **10,723,200.00** | **0.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 749,200.00 | 939,620.00 | -190,420.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 800,000.00 | 800,000.00 | 0.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,903,600.00 | 1,722,040.00 | 181,560.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,078,500.00 | 830,300.00 | 248,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 368,200.00 | 616,400.00 | -248,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,823,700.00 | 5,814,840.00 | 8,860.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **26,670,200.00** | **26,670,200.00** | **0.00** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,265,300.00 | 1,265,300.00 | 0.00 |
| 210502 | Хоол, хүнс | 18,553,400.00 | 18,553,400.00 | 0.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,851,500.00 | 6,851,500.00 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **30,117,900.00** | **30,117,900.00** | **0.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 18,100,000.00 | 18,100,000.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,017,900.00 | 12,017,900.00 | 0.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **506,500.00** | **506,500.00** | **0.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 506,500.00 | 506,500.00 | 0.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **3,064,100.00** | **3,064,100.00** | **0.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,912,100.00 | 1,912,100.00 | 0.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,152,000.00 | 1,152,000.00 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **4,748,200.00** | **4,748,200.00** | **0.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,748,200.00 | 4,748,200.00 | 0.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **33,911,300.00** | **33,911,300.00** | **0.00** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **0.00** | **0.00** | **0.00** |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 0.00 | 0.00 | 0.00 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 0.00 | 0.00 | 0.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **33,911,300.00** | **33,911,300.00** | 0.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 33,211,300.00 | 33,211,300.00 | **0.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 700,000.00 | 700,000.00 | 0.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | | |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,392,498,500.00** | **1,387,064,693.30** | **0.00** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,201,799,300.00** | **1,199,709,402.59** | **0.00** |
| 310003 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,201,799,300.00 | 1,199,709,042.59 | |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **190,699,200.00** | **187,355,650.71** | **3,343,549.29** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 190,699,200.00 | 187,355,650.71 | 3,343,549.29 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1.00** | **1.00** | **1.00** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **85.00** | **85.00** | **85.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 5.00 | 5.00 | 5.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 58.00 | 58.00 | 58.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 22.00 | 22.00 | 22.00 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | **1,036.00** | **1,036.00** | **1,036.00** |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | **1,036.00** | **1,036.00** | **1,036.00** |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 1,036.00 | 1,036.00 | 1,036.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

| д/д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **21,913,917.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **21,913,917.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **15,237,819.00** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 3,112,122.00 |
| 210101 | Үндсэн цалин | | 3,112,122.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 485,707.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 485,707.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 978,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 556,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 422,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 160,000.00 |
| 210604 | Урсгал засвар | | 160,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 10,501,990.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 10,501,990.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **6,676,098.00** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | |
| | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | | 6,676,098.00 |
| **1** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | **21,913,917.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **21,913,917.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 21,753,917.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 160,000.00 |
| | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн */цаашид Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль гэх/* 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-ийн аудитын менежер И.Туяа гүйцэтгэж, хяналтыг тус компанийн захирал Ш.Ичинхорлоо, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эх хэлээрээ зөв ярьж, бодол санаагаа ойлгомжтой илэрхийлэх уншиж бичиж, сурах;
- Тоо бодох, түүнийг амьдрал ахиудаа хэрэглэж сурах;
- Хүрээлэн байгаа орчны үзэгдэл, юмсын талаар зохих шатны мэдлэг эзэмшүүлэх;
- Гоо зүй, хүмүүнлэг, үндэсний дэвшилт, ёс, заншил, соёлын өв уламжлал, эрүүл ахуйн зохих шатны мэдлэг чадвар эзэмшүүлэх;
- Өөрийн болон бусдын хөдөлмөрийг хүндэтгэх, үнэнч шударга хамтач байдлыг эрхэмлэх үзэл төлөвшүүлэх;
- Бие дааж сурах арга барил эзэмшүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- МУЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д: “Нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана”; /2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/
- МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор баталсан “Ковид 19” цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай”;
- МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 267 дугаар тушаалаар баталсан “Цахилгаан, дулааны уурын хангамж, хэрэглээг зохицуулах тухай”.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн захирлын 2021 оны А/10 дугаар тушаалаар сургуулийн дотоод хяналтын багийг 6 хүний бүрэлдэхүүнтэй томилуулан ажиллуулжээ. 2020-2021 оны хичээлийн жилд дотоод хяналтын баг 6 чиглэлд хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс 100 хувь гүйцэтгэж, хяналт шалгалтын тайлангаар илэрсэн зөрчил дутагдлыг засч залруулах зөвлөмж өгөгдөж, биелэлтийг үнэлж дүгнэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

## 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 1,392,498.5 мянган төгрөгийн 2 хувиар буюу 27,849.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 20,887.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1.8 хувиар буюу 73,501.5 мянган төгрөгөөр өссөн ба өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| **Б** | **1** | **2** | **3=2-1** |
| Мөнгөн хөрөнгө | 0.00 | 0.00 | 0.00 |
| Авлага | 0.00 | 0.00 | 0.00 |
| Бараа материал | 31,390.7 | 42,089.9 | 10,699.2 |
| Үндсэн хөрөнгө | 4,200,946.8 | 4,116,746.1 | (84,200.7) |
| **Нийт хөрөнгө** | **4,232,337.5** | **4,158,836.0** | **(73,501.5)** |
| Богино хугацаат өр төлбөр | 0.00 | 0.00 | 0.00 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 4,232,337.5 | 4,158,836.0 | (73,501.5) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **4,232,337.5** | **4,158,836.0** | **(73,501.5)** |

Бараа материалын дансны үлдэгдэл 42,089.9 мянган төгрөг болж 10,669.2 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материал, аж ахуйн материал, бусад хангамжийн материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 82,036.4 мянган төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 14,707.8 мянган төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 86,065.0 мянган төгрөгийн материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,116,746.1 мянган төгрөг болж 84,200.7 мянган төгрөгөөр буурсан нь тухайн оны элэгдлийн зардал 109,128.8 мянган төгрөг байгаатай холбоотой ба тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 21,095.0 төгрөгийн машин тоног төхөөрөмж бэлтгэж, 3,833.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгө үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, акталж устгасан хөрөнгө байхгүй байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 73,501.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 69,907.5 мянган төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого буурснаас шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 46,249.1 мянган төгрөгөөр өссөн нь урсгал шилжүүлгийн зардал буурснаас голлон шалтгаалсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 1,322,234.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 70,264.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 1,392,498.5 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээнд тусгай зориулалтын шилжүүлгээр 1,201,799.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөр 190,699.2 мянган төгрөг, нийт 1,392,498.5 мянган төгрөгийн төсөв баталжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 1,201,799.3 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 187,355.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,387,064.6 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 2,090.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,387,064.6 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 4,180.5 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3,343.5 мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн БШУЯ-наас 11,480.0 мянган төгрөг, Мандал сумын нэгдсэн эмнэлгээс Ковид-19 цар тахлын үед ажилласан албан хаагчдын илүү цагийн хөлс 3,597.8 мянган төгрөг, түрээсийн

номны үнэ 6,676.1 мянган төгрөг, заалны түрээсийн 160.0 мянган төгрөг зэрэг нийт **21,913.9** мянган төгрөгийн орлого бүрдүүлж, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

**1.**БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай ” тушаалын хоёрдугаар хавсралт “*Короновируст халдварын үед ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалт зохион байгуулахад мөрдөх түр журам*”-ын дагуу хичээл сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

**2**. Тайлант онд Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль БШУЯ-наас хэрэгжүүлж буй “E-FIRST” төсөл арга хэмжээнд хамрагдаж, төслийн хүрээнд 11,480.0 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансанд хүлээн авч зарцуулсан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 125 мэдээллийг хугацаандаа мэдээлэн 24 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн тайлант оны үйл ажиллагаанд 1,392,498.5 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1,387,064.7 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 0.4 хувиар хэмнэсэн нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: *“.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”* гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад дараах байдалтай байна.

*Хүснэгт-3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 2 | 5,183.3 | 2 | 5,183.3 | - | - | 100 |
| **Нийт дүн** | **2** | **5,183.3** | **2** | **5,183.3** | **-** | **-** | **100** |

Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлагнал болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжүүдийг биелүүлж ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 70,489.5 мянган төгрөгийн 16 алдаа зөрчил илэрснээс 70,489.5 мянган төгрөгийн 15 алдааг залруулж, 1 алдаа, зөрчилд 1 зөвлөмж өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн үр дүнгийн тайланд 70,489.5 мянган төгрөгийн алдааг тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- цалин хөлс, нэмэгдэл, НДШ-ийн зардал 231.5 мянган төгрөгөөр
- эрүүл мэндийн даатгалын зардал 407.1 мянган төгрөгөөр
- бичиг хэргийн зардал 48.6 мянган төгрөгөөр
- эм бэлдмэл эмнэлгийн хэрэгслийн зардал 56.4 мянган төгрөгөөр
- хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардал 22.7 мянган төгрөгөөр тус тус илүү илэрхийлсэн,
- бараа үйлчилгээний бусад зардал 347.6 мянган төгрөгөөр
- урамшууллын зардал 407.1 мянган төгрөгөөр
- тээвэр шатахууны зардал 377.0 мянган төгрөгөөр

- хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардал 35.1 мянган төгрөгөөр
- бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардал 1,341.8 мянган төгрөгөөр
- хоол хүнсний зардал 14,086.8 мянган төгрөгөөр
- нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардал 8,894.3 мянган төгрөгөөр
- эд хогшил, урсгал засварын зардал 26,664.5 мянган төгрөгөөр,
- бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 2,995.0 мянган төгрөгөөр тус тус дутуу илэрхийлэгдсэн,
- Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардлын / үдийн цайны / 14,574.0 мянган төгрөгийг бараа материалын дансаар дамжуулалгүй шууд зардалд бичсэн.

### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал***

*1.1 <u>Илрүүлэлт:</u>* Шилэн дансанд мэдээлбэл зохих ***24*** мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>:* Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх заалтуудыг мөрдөж, холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Сэлэнгэ аймгийн Мандал сумын 4 дүгээр сургууль | 16 | 70,489.5 | 15 | 70,489.5 | - | - | - | - | 1 | |